



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН  
ИНЖЕНЕРИЙН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Г.ЭНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-12 № 04/56

Зөвшөөрөлгүй нээсэн дансыг хаалгах тухай

ХААИС-ийн 2012 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад Төрийн банкинд дахь "Инженерийн сургуулийн хөгжлийн сан" нэртэй 3400035147 тоот төсвийн гадуур данс ашиглан 40000.0 мянган төгрөгийн албан ажлын хэрэгцээнд автомашин, 32581.2 мянган төгрөгийн сургалтын үйл ажиллагааны материаллаг баазыг бэхжүүлэх зориулалттай тоног төхөөрөмж бэлтгэсэн бүгд 72581.2 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх" заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ШААРДАХ НЬ:

"Инженерийн сургуулийн хөгжлийн сан" нэртэй төсвийн гадуур дансыг хаах, албан ажлын хэрэгцээний автомашин, сургалтын тоног төхөөрөмж бусад гарын авлага материалыг холбогдох данс бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Инженерийн сургуулийн захирал Г.Энхбаяр, тэнхимийн эрхлэгч Б. Нямгэрэл нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛСЭН:

ҮАГ-ын Ахлах аудитор

Ньюдийл Аудит ХХК-ийн захирал

Ц.Гэрэл

Э.Эрдэнэбат



070159